



МОНГОЛ УЛСЫН
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ
ТОГТООЛ

2021 оны 5 сарын 24 өдөр

Дугаар 56

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.2 дахь заалт, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 152 дугаар тогтоолыг үндэслэн ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн үед зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авах, зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авах үед коронавируст халдвар (Ковид-19)-аас сэргийлэх ажлыг зохион байгуулалтын нэгдсэн удирдлагаар хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг хавсралтад дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

2.Зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авах ажиллагааг зохион байгуулах үед халдварын эрсдэлээс сэргийлэх талаар даалгавар, чиглэл гаргаж сонгуулийн хороодод хүргүүлэх, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Ажлын хэсэг /Д.Баяндүүрэн/-т үүрэг болгосугай.

3.Ажлын хэсгийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Нарийн бичгийн дарга /Д.Даваа-Очир/-д даалгасугай.

ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА




П.ДЭЛГЭРНАРАН

Д.ДАВАА-ОЧИР

00000121

Сонгуулийн ерөнхий хорооны
2021 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн
56 дугаар тогтоолын хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, Ажлын албаны дарга	Д.Баяндүүрэн
Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Сонгуулийн ерөнхий хорооны Сонгогчийн боловсрол, сургалтын төвийн ахлах шинжээч	Б.Нямсүрэн
Ажлын хэсгийн гишүүд Онцгой байдлын ерөнхий газрын Тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга	Ж.Чүлтэмсүрэн
Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлого хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн	Б.Долгорсүрэн
Эрүүл мэндийн яамны Хөдөлмөрийн эрүүл ахуй асуудал хариуцсан мэргэжилтэн	Б.Жаргал
Нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга	Б.Бямбадорж
Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Эрүүл ахуйн хэлтсийн дарга	Л.Гэрэлмаа
Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Эрүүл ахуй, халдвар, хамгааллын хяналтын улсын байцаагч	Г.Цолмонбаяр
Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эрх зүйн хэлтсийн дарга	Б.Хэрлэнчимэг
Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний бүртгэлийн газрын мэргэжилтэн	Н.Наранцэцэг
Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн Захиргааны албаны дарга	Ц.Энхбаяр
Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн Чанарын албаны дарга	У.Нармандах

Сонгуулийн ерөнхий хорооны
Сонгогчийн боловсрол, сургалтын төвийн
референт

З.Бадмаараг

Сонгуулийн ерөнхий хорооны
Хууль эрх зүйн хэлтсийн ахлах шинжээч

Ө.Одсүрэн

Нийслэлийн сонгуулийн хорооны
гишүүн

Ү.Ганболд

Хүний их эмч, доктор

Я.Буянжаргал

---oOo---